



ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ /1996-2016/

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төг/	Нийт зарласан ногдол ашгийн дүн /төг/	Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төг/	Нийт зарласан ногдол ашгийн дүн /төг/
1996	61	475,868,625	2010	100	780,112,500
1997	154	1,199,813,025	2011	100	780,112,500
1998	150	1,170,168,750	2012	125	975,140,625
1999	166	1,294,986,750	2013	130	1,014,146,250
2000	100	780,112,500	2014	140	1,092,157,500
2001	20	157,270,680	2015	140	1,092,157,500
2005	60	468,067,500	2016	200	1,560,225,000
2006	60	468,067,500			

2015 ОНЫ НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

	Хувьцааны тоо	%	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг	Ногдол ашгийн дүн
Зарласан ногдол ашиг	7,801,125	100%	140	1,092,157,500
Олгосон ногдол ашиг /2017.02.28-ны байдлаар/	7,017,328	90%	140	982,425,920

Говь ХК нь 2010-2014 онуудад зарласан ногдол ашгаа тухайн жилдээ багтаан Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% тараасан. Харин 2015 онд зарласан ногдол ашгийг компани дээрээ олгохоор шийдвэрлэсэн бөгөөд, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай шилжүүлж байна. 2017.02.28-ны өдрийн байдлаар 2015 онд зарласан ногдол ашгийн 90 хувь буюу 982,425,920 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд тараагаад байна. Ногдол ашгаа авч амжаагүй байгаа хувьцаа эзэмшигчид хүссэн үедээ Говь ХК-ийн байранд ирж бэлэн мөнгөөр болон өөрийн харилцах дансанд шилжүүлүүлэн авах боломжтой.

2016 ОНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ, ТҮҮНИЙГ ТАРААХ ЖУРАМ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн, чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг өсгөж, хувьцаанд ногдол ашиг тогтмол тараахыг эрмэлзэж байгаа билээ.

Иймээс Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 2 сарын 10-ны өдрийн хурлын №2 тогтоолоор 2016 оны санхүүгийн үр дүнгээс хувьцааны нэгж тутамд 200 төгрөгийн ногдол ашиг буюу цэвэр ашгийн 9.7 хувийг ногдол ашигт тараахаар боллоо. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нэгж хувьцаанд ногдол ашгийн хэмжээ 42.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2016 оны ногдол ашгийг 2016 оны 4 сарын 20-ны өдрөөс эхлэн компани дээрээ бэлэн мөнгөөр тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох болно.